ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2023 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ
(Шинэжинст сум)

2023 оны 12 дугаар сарын 25

Залаа

| Д/д | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллагын үнэлгээ |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | | |
| 1 | 1.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилт, зорилго, үйл ажиллагааны чиглэл, бүтэц, орон тооны зар, тухайн жилийн батлагдсан төсөв, үйл ажиллагааны мэдээллийг холбогдох сайт, фейсбүүк, сайтуудад байршуулж олон нийтэд ил тод нээлттэй мэдээлдэг. Засаг даргын захирамж, байгууллагын даргын тушаал шийдвэрийг тухай бүрд нь сумын олон нийтийн сүлжээ цахимаар иргэдэд нээлттэй хүргэдэг. | 100% | 70% |
| 2 | 1.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Сумын хэмжээнд 6 албан байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд сумын төвдөө байршиж бүтэц зохион байгуулалт, харилцах утас хаягийг олон нийттэй харилцах чиглэлээр цахимд байршуулж ажилласан. Төрийн байгууллагууд "Шинэжинст ЗДТГ" группэд албан мэдээллүүдээ оруулдаг пейжтэй. Хамгийн олон дагагчтай "Залаажинст" группэд мэдээллийг шэйрлэж түгээдэг. Байгаль орчны холбоотой асуудал, ажил байдлыг "Шинэжинст сумын байгаль" группээр, Сургууль "Шинэжинст сумын эцэг эхчүүд, ЭМТ нь "Шинэжинст сумын ЭМТ, Шинэжинст Соёлын төв гэсэн байгууллагуудаас мэдээлэл хүргэдэг нийгмийн цахим сүлжээний хаягуудтай юм. Төрийн захиргааны 9, төрийн үйлчилгээний 9, Улс төрийн албан хаагч 2 нийт 20 орон тоог Засаг даргын Тамгын даргын А/01 тушаалаар батлан ажиллаж байна. Ажилтан албан тушаалтнуудын нэр хаяг, ажлын чиг үүрэг, холбоо барих утасны дугаар, хаяг, цагийн хуваарийг ажилтнуудын өрөөний үүдэнд шинэчлэн хийж байршуулсан. Мөн веб сайтад Албан хаагчдын утасны дугаарын бүртгэлийн оруулсан. | 100% | 100% |
| 3 | 1.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, | Санхүүгийн хяналт дотоод аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% | 0% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | | | |
| 4 | 1.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Засаг даргын Тамгын газраас мэдээллийн самбар болон сумын нэгдсэн зарын цахим группүүдээр холбогдох хууль тогтоомж журам зааврыг тогтмол сурталчлан ажиллаж байна. Долоо хоног бүрийн 3 дахь өдрийн 17:00 цагаас Хууль эрх зүйн мэдлэг олгох Мэдээллийн цагийг төрийн албан хаагчид болон ард иргэдэд хийж хэвшсэн ба 2023 оны 01 сараас хойш 18 удаагийн сургалт зохион байгуулагдсан байна. Мөн Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа албан тушаалтнуудын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашигладаг хууль тогтоомж дүрэм журмыг сумын цахим нийтийн сүлжээнд байршуулан шинэчилдэг. Санхүүгийн албанаас мэдээллийн самбарт сарын мэдээг дараа сарын эхэнд байнга шинэчилж байна. | 100% | Х.Б |
| 5 | 1.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Мөрдөгдөж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хагас жилийн байдлаар хугацаанд нь тайлагнасан. Үүнд: 1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 87 хувь (2023.12,20-нд). 2. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2023.12.15-нд тайлагнасан 89 хувьтай. 3. Дэд хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувь (2023.12.10-нд) 4. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлт 88 хувь (2023.12.25-нд) -иар одоогоор тайлагнасан байна. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтүүдийг сар, улирал бүр тайлагнан ажиллаж байна. Хугацаа хоцролгүй тайлагнахын тулд бүх албан хаагчдад Хууль, Эрх зүйн ажилтны эрхийг өгч албан хаагч бүр цаг тухайд нь тайлагнах эсэхэд эрх зүйн ажилтан хяналт тавин ажиллаж байна. Хууль, тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2023 оны 02 дугаар сараас эхлэн сар бүр тайлагнадаг болсон. Үүнтэй холбогдуулан сар бүр хугацаа хоцролгүй тайлагнаж, нийт 10 сарын дунджаар 75,6%-тай тайлагнасан. Бусад улирал бүр тайлагнадаг хэрэгжилтүүдийг энэ оны хувьд хугацаа хоцролтгүй бүрэн гүйцэт тайлагнаж хэвшээд байна. | 100% | 0% |
| 6 | 1.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Засаг даргын Тамгын газраас мэдээллийн самбар болон сумын нэгдсэн зарын цахим группүүдээр холбогдох хууль тогтоомж журам зааврыг тогтмол сурталчлан ажиллаж байна. Долоо хоног бүрийн 3 дахь өдрийн 17:00 цагаас Хууль эрх зүйн мэдлэг олгох Мэдээллийн цагийг төрийн албан хаагчид болон ард иргэдэд хийж хэвшсэн ба 2023 оны 01 сараас хойш 18 | 100% | 30% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| --- | --- | --- | --- | --- |
| | | удаагийн сургалт зохион байгуулагдсан байна. Мөн Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа албан тушаалтнуудын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашигладаг хууль тогтоомж дүрэм журмыг сумын цахим нийтийн сүлжээнд байршуулан шинэчилдэг. Санхүүгийн албанаас мэдээллийн самбарт сарын мэдээг дараа сарын эхэнд байнга шинэчилж байна. | | |
| 7 | 1.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | Ажилтан албан тушаалтнуудын нэр хаяг, ажлын чиг үүрэг, холбоо барих утасны дугаар, хаяг, цагийн хуваарийг ажилтнуудын өрөөний үүдэнд шинэчлэн хийж байршуулсан. Мөн веб сайтад Албан хаагчдын утасны дугаарын бүртгэлийн оруулсан. | 100% | 70% |
| 8 | 1.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ | 2023 оны хагас жилийн байдлаар манай байгууллагад 35 өргөдөл ирснээс шийдвэрлээгүй өргөдөл байхгүй. Ажил хүссэн болон ажлаас чөлөөлөгдөхийг хүссэн агуулгатай өргөдлүүд болно. Өргөдлийг https://eoffice.bayanhongor.gov.mn/login сайтад бүртгэн, шийдвэрлэж байна. | 100% | 0% |
| 9 | 1.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Сумын засаг даргын 2022 оны 12-р сарын 5 өдрийн А/119 захирамжаар томилогдсон албан хаагчид тооллогын ажлыг хугацаанд нь амжилттай зохион байгууллаа. Үүнд тэмээ-6598, адуу-1706, үхэр-371, хонь-20227,ямаа-132359 бүгд 161261 тоо толгой мал тоологдлоо.Өмнөх оны үзүүлэлтээс 35538 тоо толгой малаар өссөн дүнтэй байна.2022 оны суурин хүн амын тоо-2582 үүнээс эрэгтэй-1272, эмэгтэй-1310, нийт өрх-804, 2023 оны хагас жилийн түүвэр судалгааг 107 өрхийн 20053 тоо толгой мал тоологдож хугацаанд нь программд шивж оруулсан. Статистик мэдээ тайланг графикт хугацаанд нь гаргаж sudalgaa.1212.mn сайтад шивж оруулаа. | 100% | 70% |
| 10 | 1.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр | Малчин иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг ойртуулж "Малчид төлчдийн зөвлөгөөн"-ийг 2023 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд зохион байгуулсан. Ард иргэдийн санал хүсэлтийг сонсох, мөн иргэдэд хэрэгтэй сургалт зөвлөгөөнийг орсон. Сургалтыг Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Содончимэг, Б.Батцэнгэл нар Хүүхдийн эрхийн талаар сургалт орсон. 6 дугаар 15-ны өдрөөс эхлэн бүх багийн иргэдэд ээлжээр хурал зохион байгуулж байна. Хурлаар иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, Цахим сайт, Орон нутгийн хөгжлийн сангийн санал асуулгыг онлайнаар хэрхэн өгөх талаар мэдээлэл хийсэн. | 100% | 0% |
| Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 11 | 2.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Сумын Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн зэрэг төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлэн тус албан тушаалын албан үүргийг Тамгын газрын ажил мэргэжил ойр албан хаагчдад хавсран гүйцэтгүүлж байна. Мөн Сургуулийн захирлын сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 3 удаа хүргүүлсэн ба 2022-2023 оны хичээлийн жилд тус албан тушаалын албан үүргийг Сургалтын менежер хавсран гүйцэтгэв. Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж, байгууллагын сул орон тооны захиалга, сонгон шалгаруулалтын зар, шинээр томилогдсон ажилтан албан тушаалтантай холбоотой гарсан шийдвэрүүдийг тухай бүр цахим хуудаст байршуулж сонгон шалгаруулалтын үр дүнг нийтэд байнга мэдээлдэг. Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системд албан хаагчдын мэдээллийг тогтмол оруулж шинэчилдэг. | 100% | 30% |
| 12 | 2.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Төрийн захиргааны албан хаагчийн хувьд төрийн албаны шалгалтад тэнцсэн иргэнийг томилж байна. 2023 оны Хагас жилийн байдлаар Төрийн захиргааны 3 сул орон тооны захиалга хүргүүлсэн. Үүний хүрээнд ард иргэдийн хурал, зөвлөгөөн, Шинэжинст сумын цахим сайтууд дээр Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Жижиг дунд үйлдвэрлэлийн мэргэжилтэн, Хууль эрх зүйн мэргэжилтний орон тоо дутагдалтай байгаа талаар мэдээлэл хийж, холбогдох мэргэжилтэн төрийн албаны шалгалт өгөхийг уриалж ажиллаж байна. Төрийн үйлчилгээний сул орон тоог Шинэжинст ЗДТГ, Залаажинст, Нээлттэй засаг-Шинэжинст, Shinejinst Shinejinst гэсэн цахим хуудсанд нээлттэй зарлан анкетыг хүлээн авч, удирдлагын багийн сонгон шалгаруулалтын үр дүнгээр томилж байна. Сонгон шалгаруулалт явуулах журам, үнэлгээний тайланг ажил горилогч нарт нээлттэй танилцуулан ажилладаг. | 100% | 0% |
| 13 | 2.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн А/08 тушаалаар Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулсан. Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 129 дүгээр тогтоолын дагуу "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журмын дагуу албан хаагчдад арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. | 100% | 0% |
| 14 | 2.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж, байгууллагын сул орон тооны захиалга, сонгон шалгаруулалтын зар, шинээр томилогдсон ажилтан албан тушаалтантай холбоотой гарсан шийдвэрүүдийг тухай бүр цахим | 100% | 0% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | хуудаст байршуулж сонгон шалгаруулалтын үр дүнг нийтэд байнга мэдээлдэг. Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системд албан хаагчдын мэдээллийг тогтмол оруулж шинэчилдэг. | | |
| 15 | 2.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж, байгууллагын сул орон тооны захиалга, сонгон шалгаруулалтын зар, шинээр томилогдсон ажилтан албан тушаалтантай холбоотой гарсан шийдвэрүүдийг тухай бүр цахим хуудаст байршуулж сонгон шалгаруулалтын үр дүнг нийтэд байнга мэдээлдэг. Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системд албан хаагчдын мэдээллийг тогтмол оруулж шинэчилдэг. | 100% | 0% |
| 16 | 2.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Төрийн захиргааны албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг Засгийн газрын 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын дагуу Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлалын дагуу хагас бүтэн жилээр үнэлэн урамшуулал олгон ажиллаж байна. | 100% | 0% |
| | Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 17 | 3.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн нэгтгэсэн тайлан Төрийн Аудитын байгууллагаар аудит хийлгэж "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт авсан. Тайлант оны төсөв батлагдсан хуваарийн дагуу зарцуулагдаж байна. Дараа оны төсвийн төслийн хугацаа болоогүй байгаа. | 100% | 0% |
| 18 | 3.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Төсөвт албан газруудын санхүүгийн тайланг хагас жилээр гарган баталгаажуулж Э тайлангийн программд шивж оруулан нэгтгэж Санхүү төрийн сангийн хэлтсээр хянуулан баталгаажуулсан. | 100% | 0% |
| 19 | 3.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | 2022 оны төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулан "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт авсан. | 100% | 0% |
| 20 | 3.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Төсөвт төвлөрөх төлбөр хураамжийн орлого тайлант хугацаанд өөрчлөгдөөгүй. | 100% | 0% |
| 21 | 3.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | 2022 оны төсвийн хэмнэлтийг жилийн эцсээр орон нутгийн Ерөнхийорлогын дансанд төвлөрүүлж тайлант онд зарцуулсан. | 100% | 100% |
| 22 | 3.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудыг Сумын Веб сайт, Шилэн данс, байгууллагын төсвийн ил тодын самбарт байршуулж тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn сайтад байршуулж байна. | 100% | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 23 | 3.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Санхүү төрийн сангийн хэлтсээс авсан санхүүгийн дэмжлэгийг шилэн дансанд байршуулсан. | 100% | 30% |
| 24 | 3.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | Хөрөнгө зарцуулах Засаг даргын захирамж, гэрээг шилэн данс болон төсвийн ил тодын самбарт байршуулж байна | 100% | 100% |
| 25 | 3.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | Шилэн дансыг байгууллагуудын нягтлан бодогч нар хариуцан сар бүрийн 08-ны дотор байршуулан Санхүү төрийн сангийн хэлтсээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг тухай бүр хүргүүлж байна. | 100% | 30% |
| 26 | 3.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу ажлуудыг бүрэн хийж дуусган хөрөнгийг ашиглаж байна. Он дамжин хийгдэж байгаа Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажил барилга эхлэх зөвшөөрөлгүй эхэлсэн гэдэг шалтгаанаар барилгын ажил зогссон байгаа. Гүйцэтгэгч ГУА-ОРД ХХкомпанид ажлыг дуусгах талаар Засаг даргын албан тоот хүргүүлсэн. Мөн Өвөрхангай аймгийн шүүхэд хандсан болович албан ёсны хариу ирээгүй байна. 2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 13 ажил хийхээр батлагдсан: Үүнд: 1.Бэлчээрийн уст цэгийн хайгуул хийх /1-р баг/, 2. Бэлчээрийн уст цэгийн хайгуул хийх /2-р баг/, ажлуудыг ажил тус бүрээр нь Гео дата процессинг ХХК-тай 7,0, 14,0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж ажлыг бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөн. 3. 04-н шугамын өргөтгөл хийх 250 ква-ийн дэд станц барих ажлыг tender.gov.mn сайтад цахимаар зарлаж гүйцэтгэгчээр "Гарьд системс" ХХК шалгарч 210317268 төгрөгийн гэрээ байгуулж, ажлыг бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөн шаардлагат нийцүүлэн хүлээлгэн өгч хөрөнгийг ашиглаж байна. Засаг даргын Тамгын газрын ажлын хэсэг хяналт тавьсан. 4. Биеийн тамирын гадаа талбай байгуулах ажлыг Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn сайтаар нээлттэй тендер зарлан "Элбэг констракшн" ххк-2023-2024 онд 1367898542 төгрөгөөр ажлыг хийж гүйцэтгэх гэрээ байгуулан 2023 онд хийх ажлаа бүрэн хийж гүйцэтгэсэн | 100% | 30% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлсэн. Энэ ажлын гүйцэтгэлд Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын ажлын хэсэг томилогдон ажлын гүйцэтгэлд хяналт тавьсан. 5.Гудамж талбайн гэрэлтүүлгийн өргөтгөл хийх ажлын тендерийг цахимаар зарлаж гүйцэтгэгчээр “Ган утас мөнх” ххк шалгарч132283202 төгрөгөөр ажлыг хийж гүйцэтгэн холболтыг бүрэн хийгээгүй гэдэг шалтгаанаар 6 ширхэг цамхаган гэрэл асахгүй байна. 6. Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын тендерийг цахимаар зарлаж “Номгоны андууд” ХХК шалгарч 64550000. | | |
| 27 | 3.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт; | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийсэн ажлын санхүүгийн тайланд аудит хийж зөрчилгүй дүгнэлт авсан. | 100% | 0% |
| 28 | 3.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг сумын веб сайт болон сумын фейсбүүк группэд цаг тухай бүр байршуулж байна. | 100% | 100% |
| 29 | 3.13. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Спорт заал” шинээр барих ажлыг “Буян арвижих од” ХХК 873 сая төгрөгөөр бүрэн дуусаж хийж гүйцэтгэсэн. 2022 оноос ажил эхэлж нийт гүйцэтгэх ажлын 80%-ийг хийж, 2023 онд үлдэх 20%-ийн ажлыг бүрэн гүйцэтгэж дуусган аймгаас мэргэжлийн байгууллагаас хариуцсан мэргэжилтнүүдийг авчирч газар дээр нь шалгуулан дутуу байсан ажлуудыг гүйцээн орон нутагт хүлээлгэн өгсөн. Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажил Аймгийн Орон нутгийн өмчийн газраас эрх шилжин шууд гэрээ байгуулах албан тоот Засаг дарга дээр ирж “Плутус Велт” ХХК-тай гэрээ байгуулан 2023 онд хийх 50 сая төгрөгийн ажлыг хийж гүйцэтгэсэн. “Плутус Велт” ХХК-тай 17,0 сая төгрөгийн буудлын урсгал засвар хийх гэрээ байгуулан Засаг даргын Тамгын газрын буудлыг засварлан ашиглаж байна. | 100% | 0% |
| 30 | 3.14. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийсэн ажлуудад Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг , Сумын ИТХ-ын хяналтын ажлын хэсэг тухай бүр ажиллаж байна. | 100% | 0% |
| 31 | 3.15. хууль тогтоомжид заасан бусад. | Ил тод байдлыг хангаж ажиллаж байна | 100% | 0% |
| Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 32 | 4.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | Цалинтай холбоотой мэдээлэл болон төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. | 100% | 0% |
| 33 | 4.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. | Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 1 караоке, худалдах тусгай зөвшөөрөлтэй 34 дэлгүүрийн цагийн хуваарьт тогтмол хяналт тавьж, ард иргэдээс ирсэн 57 дуудлага мэдээлэлд түргэн шуурхай очиж ажиллалаа. Гадна гэрэлтүүлэг, камер нь ажиллагаагүй болсон 6 хүнсний дэлгүүрт хугацаатай шаардлага тавьж бүрэн хангуулав. | 70% | 0% |
| | Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |
| 34 | 5.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | Хамааралгүй заалт | Х.Б | Х.Б |
| 35 | Хамааралгүй заалт | Хамааралгүй заалт | Х.Б | Х.Б |
| 36 | 5.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг СИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 16 өдрийн 72 дугаар тогтоолоор батлуулж газрын кадастрын мэдээллийн сан, egazar.gov.mn цахим сайтад байршуулсан. Мөн 2023 оны төлөвлөгөөг иргэдэд нээлттэй байлгах талаар цахим сайтын талаар иргэдэд мэдээлэл өгч, ЗДТГ-ын зарын самбарт байршуулсан. Одоогийн байдлаар нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. | 100% | 30% |
| 37 | 5.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг СИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 16 өдрийн 72 дугаар тогтоолоор батлуулж газрын кадастрын мэдээллийн сан, egazar.gov.mn цахим сайтад байршуулсан. Мөн 2023 оны төлөвлөгөөг иргэдэд нээлттэй байлгах талаар цахим сайтын талаар иргэдэд мэдээлэл өгч, ЗДТГ-ын зарын самбарт байршуулсан. Одоогийн байдлаар нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна. Мэдээллийг цахимд байршуулсан. | 100% | 0% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 38 | 5.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг; | Хамааралгүй заалт | Х.Б | Х.Б |
| 39 | 5.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | Хамааралгүй заалт | Х.Б | Х.Б |
| 40 | 5.7. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | Энэ оны хувьд шилжүүлж, өмчлүүлсэн, ашиглалтаас гаргаснаас орсон орлого байхгүй байна. | Х.Б | Х.Б |
| 41 | 5.8. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл | Төрийн захиргааны байгууллагад хамааралгүй заалт. | Х.Б | Х.Б |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 42 | 5.9. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | Орон нутагт улсын төсвийн хөрөнгөөр баригдсан спорт заалыг улсын комиссоор хяналт тавиулж улсын комиссын зөвшөөрлөөр хүлээн авч ашиглаж байна. | 100% | 0% |
| 43 | 5.10. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ; | Тус сумын нутагт ЭрдэнэМонгол ХХК нь тусгай зөвшөөрөл эзэмшдэг бөгөөд "Амралтаараа ажиллая" аяныг Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөн 20 оюутныг зуны амралтаар нь ажлыг байраар хангуулж, 2 сарын хугацаанд цалинжуулж сургалтын тэтгэлэг болгох ажлыг хэрэгжүүлж эхлээд байна. Нэг оюутан 1,1 сая төгрөгийн цалин авах боломж бүрдэж байгаа юм. | 100% | 0% |
| 44 | 5.11. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; | Хамааралгүй заалт хасуулах саналтай байна. | Х.Б | Х.Б |
| 45 | 5.12. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; | Хөдөө аж ахуйн салбарт Мал зүйч ийн мэргэжил хомс байгаа. Үүний хүрээнд 1 оюутан Аймгийн Хөдөө аж ахуйн газар, Сумын засаг даргатай гурвалсан гэрээ байгуулан 4 жилээр суралцаж байна. Тус суралцаж байгаа оюутны мэдээллийг shinejinst.gov.mn сайтад Тэтгэлэг цэс нээн байршуулан ажиллаж байна. | 100% | 0% |
| 46 | 5.13. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. | 2023 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Малчид төлчдийн зөвлөгөөний үеэр нийт 268 иргэнд, 2023 оны 06 дугаар сард Багуудын хагас жилийн тайлан тавих хурал сумын төвд болсон тул АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном зэргийг дэлгэц ашиглан тус тус танилцуулсан. Мөн авлигын эсрэг мэдээллийг Залаажинст, Шинэжжинст ЗДТГ, shinejinst shinejinst Зэрэг сошиалд шэйрлэж ажиллаж байна. | 70% | 70% |

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.БАТХУЯГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.БАТЧИМЭГ

# ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

(Өөрийн үнэлгээ)

2023 оны 12 дугаар сарын 25

Залаа

| ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ | | | |
|---|---|---|---|
| Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 46 | | | |
| Үүнээс | Үр дүнтэй | **100%** | **37** |
| | Тодорхой үр дүнд хүрсэн | **70-90%** | **2** |
| | Эрчимжүүлэх шаардлагатай | **30-50%** | **-** |
| | Үр дүнгүй | **0%** | **-** |
| | Хэрэгжих хугацаа болоогүй | **Х.Б** | 7 |
| | Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт 98.46% хувьтай байна. | | |

____________________oOo____________________

# ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

(Дээд шатны байгууллагын үнэлгээ)

2023 оны 12 дугаар сарын 25

Залаа

| ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ | | | |
|---|---|---|---|
| Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 46 | | | |
| Үүнээс | Үр дүнтэй | **100%** | **5** |
| | Тодорхой үр дүнд хүрсэн | **70-90%** | **4** |
| | Эрчимжүүлэх шаардлагатай | **30-50%** | **6** |
| | Үр дүнгүй | **0%** | **23** |
| | Хэрэгжих хугацаа болоогүй | **Х.Б** | 8 |
| | Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилт **25%** хувьтай байна. | | |

__________oOo__________